

**Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл  
IDA CREDIT# P174116**

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын засварын ажилд хяналт  
тавихад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд дэмжлэг үзүүлж ажиллах  
Үндэсний зөвлөхийн ажлын даалгавар**

**Үндэслэл**

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас (ХНХЯ) Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл” нь хөдөлмөрийн зах зээл дэх боломжийг ажил хайгч болон бичил бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй хүргэх, КОВИД-19 цар тахлын үед зохих шалгуур хангасан ажиллагчдад түр хугацаанд хөнгөлөлт үзүүлэх зорилготой. Төсөл нь дараах үндсэн 4 бүрэлдэхүүн хэсэгтэй.

Бүрэлдэхүүн хэсэг 1: Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагуудтай нягт хамтран ажилласнаар ажил олгогч болон ажил хайгчдад чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээг илүү үйлчлүүлэгч төвтэй болгон хөгжүүлэхэд чиглэгдэнэ. Бүрэлдэхүүн хэсэг 2: Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Бүрэлдэхүүн хэсэг 3: Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн цар хүрээ, чанар, хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. Бүрэлдэхүүн хэсэг 4: Зохих шалгуур хангасан ажиллагч, ажил олгогчдын нийгмийн даатгалын шимтгэлийг түр хугацаагаар хөнгөлөх.

Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хүрээнд дараах үндсэн ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. (а) Хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээний өнөөгийн байдалд хийсэн үнэлгээнд үндэслэн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх; (б) Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн систем (LMIS) болон мэдээллийн дэвшилтэд технологид суурилсан ажил зуучлалын үйлчилгээг нэвтрүүлэх (в) Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ)-ын мэдээллийн систем, сургалтын орчиныг сайжруулж, байр/танхимыг засварлан тохижуулах; (г) Техникийн туслалцаа, боловсон хүчнийг сургах замаар төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх.

Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хүрээнд ХХҮЕГ-ын байр, танхимыг засварласнаар хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээ хүргэх механизмыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх юм.

Одоогоор ХХҮЕГ-ын засварын зураг төсвийг боловсруулан дуусах шатандаа явж байна. ХХҮЕГ-ын 1,2,3,5,6-р давхрын нийт 3720.48м<sup>2</sup> талбайг засварлан, Хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

Барилга, хот байгуулалтын яамнаас (БХБЯ) баталсан журмын<sup>1</sup> дагуу засварын ажилд хяналт тавин ажиллах ба Барилгын хөгжлийн төвөөс (БХТ) баталсан зураг төслийн дагуу засварын ажил гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт тавих үндэсний зөвлөх авч ажиллуулахаар ХНХЯ төлөвлөж байна.

Шалгарсан зөвлөх нь “Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаалын хавсралт “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих” дүрмийг баримталж ажиллана. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй, ээлтэй орчин бүрдүүлэх,

<sup>1</sup> Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаал

ялангуяа ХНХЯ болон ХХҮЕГ-аас тодорхойлсны дагуу 1 дүгээр давхар болон бусад холбогдох хэсэгт байрлах өрөө, талбайг шинэчлэн тохижуулахад хяналт тавьж ажиллана.

Гэрээний хугацаанд Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээ (БОНУХ)-г дагаж мөрдөнө. БОНУХ-ны холбогдох хэсгүүдийг гэрээнд хавсаргана.

Зөвлөх нь БОНУХ-ын хүрээнд “Асбест-Ажил мэргэжлийн болон олон нийтийн эрүүл мэндийн асуудлууд”-ын сайн туршлагуудын талаарх тэмдэглэл, “Засварын ажлын байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон нийгмийн нөлөөллийн байдлыг үнэлэх хуудас” болон бусад холбогдох баримт бичиг, дүрэм журмын дагуу засварын ажлын гүйцэтгэлийг шалгана.

Зөвлөх нь ХНХЯ болон Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)-тэй нягт хамтран ажиллана.

Зөвлөх нь дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

<p><b>Үйл ажиллагааны хамрах хүрээ</b></p>	<p>ХХҮЕГ-ын засварын ажлын үе шатанд хяналт тавих.</p> <ol style="list-style-type: none"><li>1. Зөвлөх нь дотоодын дүрэм журмын дагуу Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн өмнөөс долоо хоногт нэг удаа газар дээр нь очиж хяналт тавьж засварын ажлын явцын талаар ХНХЯ/ТХН-д долоо хоног бүр мэдээллэнэ. Долоо хоног бүрийн тайлангаар засварын ажлын явцад тулгарч буй асуудалд цаг тухайд нь арга хэмжээ авах, мөн засварын ажлыг төлөвлөсөн хугацаанд дуусгахын тулд учирч болзошгүй асуудлын талаар ХНХЯ/ТХН-д мэдээлж, зөвлөмж өгнө.</li><li>2. ХХҮЕГ-ын засварын ажилд шаардагдах бараа, материалыг олон улсын стандартын дагуу байгаль орчин, хүний эрүүл мэндэд ээлтэй барилгын материал худалдан авахад хяналт тавина;</li><li>3. Агааржуулалтын системийг шинэчлэхэд хяналт тавина;</li><li>4. Гарын авлага/удирдамж<sup>2</sup>, стандарт, норматив<sup>3</sup> баримт бичгийн дагуу ажлын гүйцэтгэлийг шалгах, шаардлагатай бол холбогдох тест хийх, засварын явцад гарсан согог, догогдлыг илрүүлэх мөн тэдгээрийг холбогдох стандартын дагуу засварлах талаар гүйцэтгэгч компанид мэдэгдэх, үр дүнг ХНХЯ/ТХН-д мэдээллэх; Мөн засварын ажил гүйцэтгэгчийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавина;</li><li>5. “Засварын ажлын байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон нийгмийн нөлөөллийн байдлыг үнэлэх хуудас”, “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналтын тэмдэглэл”-ийн шалгуур тус бүрээр шалгаж, хянана. Хуудас бүрт оролцогч талуудын гарын үсэг зурж баталгаажуулна. Мөн барилгын ил, далд ажлуудын актыг баримтжуулсан фото зургийг хавсаргана.</li><li>6. Гүйцэтгэгч компаниас ирүүлсэн засварын явц болон гүйцэтгэлийн тайланг шалгахад ХНХЯ/ТХН-д дэмжлэг үзүүлж ажиллана.</li><li>7. Засварын ажил дууссаны дараа засварын ажлын бүрэн гүйцэтгэлийг хянасан эцсийн тайланг гаргана.</li></ol> <p>Зөвлөх нь засварын ажлыг хянахдаа гүйцэтгэгчийн асбест агуулсан материал, хог хаягдлыг (засварын явцад олдсон бол) аюулгүйгээр устгах, засварын ажилд асбест агуулсан материал ашиглахыг хориглох зэрэг байгаль орчин, хүний эрүүл мэнд, аюулгүй байдлын холбогдох үндэсний бодлого, дүрэм журам, стандартыг дагаж мөрдөж, хэрэгжүүлэхэд анхаарна.</p>
--	--

<sup>2</sup> Гарын авлагыг зураг төсөл боловсруулах дотоодын зөвлөх компани бэлтгэнэ

<sup>3</sup> Барилга, хот байгуулалтын сайдын баталсан барилгын норм, нормативын баримт бичгийн жагсаалт <https://mcis.gov.mn/mn/norm>

<p><b>Нийлүүлэх бүтээгдэхүүн</b></p>	<p>Зөвлөх нь дараах бүтээгдэхүүнийг хүлээлгэн өгнө.</p> <p><b>Нийлүүлэх бүтээгдэхүүн 1:</b> Бараа материалын татан авалт бүрэн хийгдсэн талаар болон эхний 2 давхрын засварын ажлын гүйцэтгэлийг хянасан ажлын тайлан.</p> <p><b>Нийлүүлэх бүтээгдэхүүн 2:</b> Дараагийн 2 давхрын засварын ажлын гүйцэтгэлийг хянасан тайлан.</p> <p><b>Нийлүүлэх бүтээгдэхүүн 3:</b> ХХҮЕГ-ын засварын явцыг хянасан талаарх эцсийн тайлан.</p> <p>Зөвлөх нь засварын ажлын явцад Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээ (БОНУХ)-ын дагуу асбест агуулсан материал болон бусад хар тугалга агуулсан өдрийн гэрэл, будаг, мөн ПХБ (полихлоржуулсан бифенил), мөнгөн ус, хуучин флюоресцент гэрэл зэрэг байгаль орчин, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх материал байгаа эсэхийг гүйцэтгэгч компанийн ХАБЭА-н мэргэжилтнүүдтэй хамтран ХХҮЕГ-ын талбайг шалгана<sup>4</sup>.</p> <p>Засварын явцад БОНУХ болон Гомдол барагдуулах механизмын холбогдох хэсгүүдийг шалгасан талаар тайланд тусгана.</p>
<p><b>Шаардагдах ур чадвар, туршлага</b></p>	<p>Зөвлөх нь дараах ур чадвар, туршлагатай байна:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Инженер, архитектур эсвэл бусад холбогдох чиглэлээр их дээд сургууль төгссөн байх (бакалаврын зэрэгтэй байх);</li> <li>• Барилга байгууламжийн менежмент, инженер, архитектур эсвэл холбогдох чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;</li> <li>• Инженер, барилга, засварын ажлын талаар өндөр мэдлэгтэй байх;</li> <li>• Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон барилгын тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийн мэдлэгтэй байх;</li> <li>• Багаар болон бие даан ажиллах чадвартай байх;</li> <li>• Дүн шинжилгээ хийх өндөр ур чадвартай байх;</li> </ul> <p>Зөвлөх нь өмнөх ажлын туршлагыг баримтжуулсан нотлох баримтыг гаргаж өгөх шаардлагатай.</p>
<p><b>Явцын тайлан, үр дүнг хянах</b></p>	<p>Зөвлөх нь ХНХЯ, ТХН-ийн удирдлага дор ажиллана. Зөвлөхийн ажлыг дараах үзүүлэлтүүдээр үнэлнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Ажлын даалгаварт тусгасан ажлуудыг бүрэн гүйцэтгэсэн байдал;</li> <li>-Нийлүүлэх бүтээгдэхүүнийг заасан хугацаанд гүйцэтгэсэн байдал;</li> <li>-Гүйцэтгэсэн ажлын чанар;</li> </ul>
<p><b>Хугацаа</b></p>	<p>Зөвлөх нь <b>2023 оны 12-р сарын 11-ээс 2024 оны 09-р сарын 30-ыг</b> дуустал ажиллана.</p>
<p><b>Төсөв</b></p>	<p>Гэрээний нийт дүн <b>26.000.000</b> төгрөгөөс хэтрэхгүй байна.</p>

<sup>4</sup> Гүйцэтгэгч компани асбест болон бусад байгаль орчин, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх материалыг аюулгүй устгах, зайлуулах төлөвлөгөөг боловсруулна.

<b>Тайлагналт болон төлбөр</b>	Төлбөрийг дараах байдлаар 3 хувааж төлнө: 1. Нийлүүлэх бүтээгдэхүүн 1-ийн ажлыг гүйцэтгэснээр гэрээний нийт дүнгийн 30%- <b>7.800.000</b> төгрөг 2. Нийлүүлэх бүтээгдэхүүн 2-ын ажлыг гүйцэтгэснээр гэрээний нийт дүнгийн 30%- <b>7.800.000</b> төгрөг 3. Нийлүүлэх бүтээгдэхүүн 3-ын ажлыг гүйцэтгэснээр гэрээний нийт дүнгийн 40%- <b>10.400.000</b> төгрөг
--	--

Баталсан:



С.Дамбий, Төслийн захирал, ОБҮДХЭТ

Боловсруулсан:



Ч.Дэлгэрханд, Төслийн мэргэжилтэн, ОБҮДХЭТ